



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 1/95

Сант сум

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.5, 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.8, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэл, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалт”-ын журмын 2 дугаар зүйлийн 2.1.1, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны A/02 дугаар тушаал, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны “Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” A/125 дугаар тушаал, 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 2 дугаар хуралдааны 1.1, аймгийн Засаг даргын 2023 оны “Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” A/303 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд bog малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 31-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 25-ны өдөр хүртэл 25 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2.Дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

А.Одхүү

(Засаг даргын Тамгын газрын дарга )

Гишүүд:

Д.Бямбацэцэг

(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт менежмент малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн )

Г.Анхбаяр

(МЭТ-ын тархвар зүйч)

Б.Золбаяр

(Хушаат 2-р багийн Засаг дарга)

Л.Сэлэнгэсайхан

(Ивэн 1-р багийн Засаг дарга)

О.Лхагвасүрэн

Боловсруулсан: *Д. Доржбаяр*

Хянасан: *Ч. Амчилгэ*

Хувь: *2*

Санал: *118 26 12*

(Сантбаянхайрхан МЭҮН-н захирал/  
 Θ.Ганбаатар  
 (Бошгын булаг ХХК-н захирал)

3. Ажлын хэсэгт даалгах нь:

3.1.Дархлаажуулалтын явцад мал амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах

3.2.Дархлаажуулах ажлаас малаа хоцроосон, зайлсхийсэн аж ахуй нэгж байгууллага, иргэд, хариуцлагагүй хандсан албан тушаалтанд хуулийн дагуу арга хэмжээ авч хариуцлага тооцох

3.3.Дархлаажуулалтын товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж бэхлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлж, малын эмчийн аюулгүй байдлыг бүрэн хангах

3.4.Энэ арга хэмжээний зорилго ач холбогдол хор хохирлын талаар ухуулга сурталчилгаа зохион байгуулах

4.Дархлаажуулалтын ажилд зарцуулагдах шатахууны зардалыг малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжүүлэхийг Санхүү албаны дарга (Г.Ууганцэцэг)-д үүрэг болгосугай.

5.Дархлаажуулалтын ажлыг товлолт хугацаанд чанартай хийж, гүйцэтгэн холбогдох мэдээ тайланг гаргаж бүрдүүлэн баталгаажуулан аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (А.Одхүү)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР